



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 40 (177)

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *Өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар авах зарим арга хэлжээний тухай*
- *Яалдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны аравдугаар сарын 30

№40 (177)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|------------|-----|
| 413. Лувсандоржийн Сүжигтэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 138 | 726 |
| 414. Зэвгийн Цэвээнравданд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 139 | 726 |
| 415. Гончигийн Цулбуурт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 140 | 726 |
| 416. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 141 | 726 |
| 417. Аман Гумирович Тулеевыг “Алтан гадас” одонгоор шагнах тухай | Дугаар 142 | 729 |
| 418. Сергей Иванович Шишкинийг “Найрамдал” медалиар шагнах тухай | Дугаар 143 | 729 |
| 419. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 145 | 729 |
| 420. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 146 | 729 |
| 421. Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай | Дугаар 147 | 730 |
| 422. Д. Мягмаржавыг Дархан-Уул аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчээр улируулан томилох тухай | Дугаар 148 | 730 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|------------|-----|
| 423. Зарим хүнийг ажилд томилох тухай | Дугаар 121 | 730 |
| 424. Н.Батбаярыг ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 122 | 731 |
| 425. Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай | Дугаар 123 | 731 |
| 426. Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай | Дугаар 124 | 731 |
| 427. Өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 125 | 732 |
| 428. Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай | Дугаар 126 | 733 |
| 429. Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай | Дугаар 127 | 733 |
| 430. Тогтоол хүчингүй болгох тухай | Дугаар 129 | 733 |
| 431. Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Дугаар 130 | 734 |
| 432. Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай | Дугаар 131 | 735 |



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар138

Улаанбаатар хот

Лувсандоржийн Сүжигтэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Хүнсний аж үйлдвэрийн салбарт удаан жил үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, чанарыг дээшлүүлэх, залуу ажилчдыг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж нийслэлийн үйлдвэрлэл,

худалдааны "Бенедакт" ХХК-ийн зөвлөх технологич Лувсандоржийн Сүжигтэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар139

Улаанбаатар хот

Зэвгийн Цэвээнравданд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад олон жил багш, хичээлийн эрхлэгчээр үр бүтээлтэй ажиллаж сургалтын арга зүйг боловсронгуй болгох, багш нарын заах ур чадварыг дээшлүүлэх, өсвөрийн залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Эрдмийн далай" цогцолбор

сургуулийн монгол хэл, уран зохиолын багш Зэвгийн Цэвээнравданд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар140

Улаанбаатар хот

Гончигийн Цулбуурт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай

Төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөөгийн хүн амыг эмчлэх, аймаг, сумдын эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүн амд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн захирал Гончигийн Цулбуурт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар141

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа, боловсрол, эрүүл мэнд, тээвэр, биеийн тамир, спорт, төр захиргааны болон төрийн бус

байгууллагад олон жил амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- | | |
|---------------------------|---|
| 1. Дамдингийн Дэмбэрэл | - Монгол Улсын Их Хурлын гишүүн, төрийн байгуулалтын байнгын хорооны дарга |
| 2. Гүндалайн Зул | - Нийслэлийн барилгын үйлдвэрлэл, худалдаа, зуучлалын "Хөнгөн бетон" ХК-ийн дэд захирал |
| 3. Жамсрангийн Сайнжаргал | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Атар-Өргөө" ХК-ийн гүйцэтгэх захирал |
| 4. Сугирын Түвшинбаяр | - Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын төвийн дарга, хөнгөн атлетикийн дасгалжуулагч |
| 5. Зэвэгийн Эрчулуун | - Дорнод аймгийн үйлдвэрлэл, худалдааны "Дорнод" ХК-ийн техникийн албаны дарга |

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- | | |
|---------------------------------|---|
| 1. Дониой Адъяа | - Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга |
| 2. Яринпилийн Алтаншагай | - Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга |
| 3. Гозгорын Аюурзана | - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт |
| 4. Содномпилын Баасанхүү | - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "ТБД-Андууд" ХХК-ийн гадаад харилцааны менежер |
| 5. Цэндийн Бадам | - Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн ахмадын хорооны дарга |
| 6. Самдангийн Балжинням | - Орхон аймгийн үйлдвэрлэл, худалдааны "Эрдэнэт хивс" ХК-ийн "Угалз" үйлдвэрийн дарга |
| 7. Доржийн Билгээ | - Монголын радио телевизийн Хэрэг эрхлэх газрын Монголын радиогийн нэвтрүүлэгч |
| 8. Цэндийн Бямбадорж | - Улаанбаатар төмөр замын олон улсын төвийн ангийн дарга |
| 9. Сүржавын Ган-Очир | - Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн ахлах их эмч |
| 10. Пуйдарын Даваа | - Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын санхүүгийн хэлтсийн дарга |
| 11. Цэрэндашийн Далантай | - Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга |
| 12. Шагдарсүрэнгийн Дангаасүрэн | - Нийслэлийн эрчим хүчний засварын үйлдвэр /УУГ/-ийн засварын мастер |
| 13. Гүржавын Дашдорж | - Завхан аймгийн Цагаанчулуут сумын Засаг дарга |
| 14. Юнрэнгийн Дашдэмбэрэл | - Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн дуудлагын их эмч |
| 15. Мөнх-Очирын Дорж | - Дорнод аймгийн Хэрлэн сумын "Жимсгэнэ" ХЭАА-н эзэн |
| 16. Түвдийн Дорж | - Монгол Улсын Их сургуулийн эдийн засгийн дээд сургуулийн багш |
| 17. Галсангийн Дөш | - Дорнод аймгийн үйлдвэрлэл, худалдааны "Дорнод" ХК-ийн мастер |
| 18. Самбуугийн Дэмбэрэл | - Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга |
| 19. Баймергений Зархум | - МАХН-ын Баян-Өлгий аймгийн хорооны дэд дарга |
| 20. Соотонгийн Лодой | - Дэд бүтцийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институтын ахлах багш |
| 21. Жадамбын Мөнхбаатар | - Завхан аймгийн Баянтэс сумын Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн дарга |
| 22. Доржийн Мөнхжаргал | - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Говь" ХК-ийн засварчин |
| 23. Жамцын Намжил | - Улаанбаатар төмөр замын Хэрэг эрхлэх газрын хөдөлмөрийн хэлтсийн дарга |
| 24. Хайсаңдайн Нацагдорж | - Ус, цаг уурын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан |
| 25. Аюурын Норжинсүрэн | - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны Засаг дарга |
| 26. Дуламын Очир | - Нийслэлийн эрчим хүчний засварын үйлдвэр /УУГ/-ийн токарьчин |
| 27. Доржийн Самдан | - Нийслэлийн эрчим хүч, үйлдвэрлэлийн "М-Си-Эс интернейшнл" ХХК-ийн ахлах инженер |
| 28. Тогоонтөмөрийн Сүхбаатар | - Улсын ерөнхий прокурорын туслах, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга |

- | | |
|--------------------------|---|
| 29. Даржаагийн Төмөрбат | - Архангай аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн эмч |
| 30. Чимэдийн Ухнай | - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх мал эмнэлгийн албаны зөвлөх малчин |
| 31. Гурбазарын Циенсүрэн | - Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн их эмч |
| 32. Намнангийн Цэндээхүү | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Атар-Өргөө" ХК-ийн ажилчин |
| 33. Батын Цэрэн | - Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэн, ахмад агрономч |
| 34. Бат-Өлзийн Цэрэндаш | - П.Н. Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлгийн дотрын зөвлөх эмч |
| 35. Жигжидийн Цэцгээ | - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газрын референт |
| 36. Гомбодоржийн Чамлай | - Монгол-Хятадын хамтарсан "Сансар кабель" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч |
| 37. Лавданжавын Шархүү | - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "ТБД-Андууд" ХХК-ийн хөдөө аж ахуйн ерөнхий менежер |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | |
|----------------------------|---|
| 1. Гомбын Алтанцэцэг | - Гэмтэл согог сэргээн засалтын клиникийн эмнэлгийн сэхээн амьдруулах тасгийн ахлах сувилагч |
| 2. Жамцын Алтанцэцэг | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын номын фондчин |
| 3. Дамдинсүрэнгийн Амар | - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Говь" ХК-ийн ажилчин |
| 4. Амгалангийн Батболд | - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Говь" ХК-ийн ажилчин |
| 5. Гооройн Баянзул | - Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн дуудлагын жолооч |
| 6. Дондогийн Буянхишиг | - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Атар өргөө" ХК-ийн ажилчин |
| 7. Банзрагчийн Бямбадорж | - Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч |
| 8. Дашдоржийн Ганболд | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын судалгаа, мэдээлэл, лавламжийн албаны дарга |
| 9. Сосорбарамын Гэрэлт | - Монгол Улсын Их Хурлын төсвийн байнгын хорооны нарийн бичгийн дарга |
| 10. Охинжавын Дамдинсүрэн | - Зорчигч тээвэр, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний "Арвин зам" ХХК-ийн жолооч-механикч |
| 11. Гончигийн Жижгээ | - Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн гагнуурчин |
| 12. Журмэдийн Мишиг | - Дорнод аймгийн Халхгол сумын "Халх-буудай" ХК-ийн нярав |
| 13. Доржийн Насанжаргал | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх |
| 14. Төвхөөний Оюунчимэг | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Атар-Өргөө" ХК-ийн ажилчин |
| 15. Дамбын Сундуй | - Зорчигч тээвэр, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний "Арвин зам" ХХК-ийн жолооч |
| 16. Сэр-Оджавын Туул | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын бичээч |
| 17. Рэнцэндоржийн Туяа | - Гэмтэл согог сэргээн засалтын клиникийн эмнэлгийн сэхээн амьдруулах тасгийн ахлах сувилагч |
| 18. Баатарын Түвшинжаргал | - Орхон аймгийн үйлдвэрлэл, худалдааны "Эрдэнэт хивс" ХК-ийн засварчин |
| 19. Дүгэржавын Уржиг | - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Атар-Өргөө" ХК-ийн ажилчин |
| 20. Төмөр-Очирын Уранчимэг | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын бичээч |
| 21. Өлзийн Хуягбаатар | - Дорнод аймгийн үйлдвэрлэл, худалдааны "Дорнод" ХК-ийн засварчин |
| 22. Дашзэвэгийн Цэндсүрэн | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын бичээч |
| 23. Гончигдоржийн Чулуун | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын судлаач |
| 24. Мажигийн Чулуунбаатар | - Монгол-Оросын хамтарсан "Монгол-росцветмет" нэгдлийн боловсон хүчин, нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| 25. Галсанжамцын Энхболд | - Хэнтий аймгийн Хэрлэн сумын гэрэл зургийн "Гэрэл" хоршооны эзэн |
| 26. Санжийн Энхтуяа | - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Говь" ХК-ийн ажилчин |
| 27. Лхагвын Юндэнгаваа | - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Атар-Өргөө" ХК-ийн засварчин |



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар142

Улаанбаатар хот

Аман Гумирович Тулеевыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гүзгийрүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Кемерово мужийн захирагч Аман Гумирович

Тулеевыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар143

Улаанбаатар хот

Сергей Иванович Шишкинийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улсад хуулийн мэргэжилтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Эрхүүгийн Улсын их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч Сергей Иванович

Шишкинийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар145

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Жагарын Байгальмааг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Даваацэрэнгийн Сарантуяаг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Лхамжавын Мөнхцэцэгийг Төв

аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Цэрэн-Очирын Оюунбилэгийг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Бадамцэрэнгийн Оюунцэцэгийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар146

Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Дашдоржийн Золзаяаг Ховд аймгийн шүүхийн

шүүгчийн, Жаргалын Сүрэнжавыг Увс аймаг дахь сум дундын Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг ноцтой зөрчсөн Лхан-Аагийн

Баасангэрэлийг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Д. Мягмаржавыг Дархан-Уул аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчээр улируулан томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Дарамын Мягмаржавыг Дархан-Уул

аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилсугай.

2. Энэхүү зарлигийг 2000 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

Зарим хүнийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дор дурдсан хүмүүсийг дараахь албан тушаалд томилсугай:

1. Ажханы Болатыг Монгол Улсын Байгаль орчны дэд сайдаар;

2. Цэвэгсүрэнгийн Тогоог Монгол Улсын Батлан хамгаалахын дэд сайдаар;

3. Баатарын Эрдэнэсүрэнг Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайдаар;

4. Сүхбаатарын Батболдыг Монгол Улсын Гадаад хэргийн дэд сайдаар;

5. Уртнасангийн Уламбаярыг Монгол Улсын Дэд бүтцийн дэд сайдаар;

6. Содномын Чинзоригийг Монгол

Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайдаар;

7. Лувсандагвын Энхтайваныг Монгол Улсын Санхүү, эдийн засгийн дэд сайдаар;

8. Халзхүүгийн Наранхүүг Монгол Улсын Үйлдвэр, худалдааны дэд сайдаар;

9. Цэнэдийн Мөнх-оргилыг Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар;

10. Дэндэвийн Тэрбишдагвыг Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайдаар;

11. Нацагийн Удвалыг Монгол Улсын Эрүүл мэндийн дэд сайдаар.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД**

Н.ЭНХБАЯР

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА**

Ө.ЭНХТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Н.Батбаярыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай 2000 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын бүрэлдэхүүн шинээр зохион байгуулагдсантай холбогдуулан Нямжавын Батбаярыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын

даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Зохион байгуулалтын өөрчлөлтийн учир Галсангийн Ганболдыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргын, Равсалын Ринчинбазарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2.Лувсандандарын Хангайг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргаар,

Балдангийн Шатарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргаар тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонтой нь холбогдуулан Цэрэндашийн Дамирэнг Дэд бүтцийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын; Дуламын Сугарыг Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын; Цэрэндуламын Шийрэвдамбыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Байгаль орчныг хамгаалах албаны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2.Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Самдангийн Банзрагчийг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргын; Сүрэнгийн Баасанхүүг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын; Даваагийн Махвалыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын; Сэтэвийн Бямбааг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын; Аюурын Зангадыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

3.Монгол Улсын Засгийн газрын бүтцэд зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан дор дурдсан хүмүүсийг дараахь

албан тушаалд томилсугай:

-Самдангийн Банзрагчийг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Сүрэнгийн Баасанхүүг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Цэгмидийн Цэнгэлийг Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Равдангийн Жадамбааг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Намжилын Түмэндэмбэрэлийг Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Цэдэнгийн Ёндонг Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Гунгаагийн Баясгаланг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Пунцагдоржийн Дамдиндоржийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргаар.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгах нь:

а/сүүлийн хоёр жил дараалан гантай байгаа аймгуудын хүсэлтийг харгалзан улсын нөөцийн өвс, тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах 452.0 сая төгрөгийн эх үүсвэрийг хянан шийдвэрлэсүгэй;

б/аймгийн Засаг даргын дэргэд аюулаас хамгаалах өвс, тэжээлийн нөөц бий болгоход зориулж Дорноговь аймагт 30.0 сая төгрөг, Өмнөговь аймагт 40.0 сая төгрөгийн эх үүсвэр гаргах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлсүгэй.

2. Өвөлжөөний болон отрын нутагт уст цэг шинээр гаргах, засварлахад шаардагдах 142.0 сая төгрөгийг төсвийн тодотголд тусгахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Аймаг дундын отрын нөөц нутаг болох Хэнтий аймгийн Хэрлэнбаян-улаан хүрэх зам дахь Хэрлэн голын Хөмүүлтэйн гүүрийг 9 дүгээр сард багтаан замын сангийн хөрөнгөөс санхүүжүүлж засварлахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

4. Хилийн зурваст хадлан бэлтгэх, мал оторлох, өвөлжих асуудлыг зохицуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, дархан цаазат газруудаас хадлангийн газар ашиглах зөвшөөрөл олгохыг Байгаль орчны сайд У.Барсболд нарт тус тус даалгасугай.

5. Хадлан тэжээл бэлтгэх, ургац хураах, алсын отор хийх зэрэг хөдөө аж ахуйн ажилд шаардагдах түлш, шатахуунаар саадгүй хангах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт даалгасугай.

6. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгах нь:

а/мал аж ахуйн өвлийн бэлтгэл хангах ажлыг тодорхой төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлсүгэй;

б/өвс, хадлан тэжээлийн улсын нөөцийг бүрдүүлж, болзошгүй байгалийн гамшгийн үед мал сүргийг хамгаалах тогтолцоо, гамшгийн тусламжийн сүлжээ бий болгох асуудлыг энэ онд багтаан боловсруулж Засгийн газарт оруулсугай;

в/мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах, өөр аймаг, сумдад отроор өвөлжих малчдын нутаг бэлчээрийг зохицуулах арга хэмжээг аймгийн Засаг дарга нартай хамтран авсугай.

7. Томоохон аж ахуйн нэгжүүдийн улсын төсөвт төлөх татвар, өр болон аж ахуй хоорондын өрийн сүлжээг барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

8. Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгах нь:

а/төвийн бүсийн нүүрсний уурхайнууд, эрчим хүчний байгууллагуудын хооронд үүссэн өрийн сүлжээг багасгах, эрчим хүчний үйлдвэрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхийн тулд тус салбарын удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлсүгэй;

б/цахилгаан станц, дулааны шугам сүлжээг өвлийн ачаалалд бэлтгэн засварлаж дуусгах, түлш нөөцлөх, цахилгаан, дулааныг хэмнэлттэй зарцуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авсугай.

9. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/малчдаар өвс, тэжээл бэлтгүүлэх, хашаа хороо, уст цэгийг засварлуулах ажлыг зохион байгуулж, аймгийн өвс, тэжээлийн нөөц бий болгох, малын өвчнөөс сэргийлэх, бууц, бэлчээрийг ариутгах, халдваргүйжүүлэх, малчдын өвөлжөөний

хуваарь гаргах, отроор өвөлжих малчид, малын тоог тогтоон малыг алсын оторт эрт гаргах зэрэг мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах арга хэмжээг 10 дугаар сарын 1-ний дотор хэрэгжүүлсүгэй;

б/нүүрс, эрчим хүч хэрэглэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлагыг 9 дүгээр сарын 15-ны дотор барагдуулах ажил зохион байгуулж, өвлийн бэлтгэлийг энэ хугацаанд хангуулж Засгийн газарт

мэдээлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ХҮНС, ХӨДӨӨ АЖ, АХУЙН САЙД
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД
ДЭД БҮТЦИЙН САЙД

Н.ЭНХБАЯР
Д.НАСАНЖАРГАЛ
Ч.УЛААН
Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар126

Улаанбаатар хот

Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Очирын Очиржавыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын; Рэгсүрэнгийн Бат-эрдэнийг Гэгээрлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2.Засгийн газрын бүтцэд зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан дор дурдсан хүмүүсийг дараахь албан тушаалд томилсугай:

-Бөөрөнхийн Мишигжавыг Боловсрол, соёл,

шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Лувсандоржийн Баяртыг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар;

-Цэрэндоржийн Содномпилийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР
Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар127

Улаанбаатар хот

Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18² дугаар зүйл, Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Тогоочийн Лхагвааг Засгийн газрын тохируулагч агентлаг-Гаалийн ерөнхий газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Хорлоогийн Баатарыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Гаалийн ерөнхий газрын даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Н.ЭНХБАЯР
Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар129

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Иргэний бүртгэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан "Иргэний овог, нэр солих журмын тухай заавар батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1966 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 392 дугаар тогтоол, "Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх заавар батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн

1984 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 204 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Н.ЭНХБАЯР
Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2000 оны 8 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 130

 Улаанбаатар
хот

Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Иргэний хамгаалалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын байнгын онцгой комиссын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

| | |
|----------------------|---|
| Комиссын дарга | -Батлан хамгаалахын сайд. |
| Орлогч дарга | -Байгаль орчны сайд; -Улсын иргэний хамгаалалтын газрын дарга. |
| Гишүүд: | -Нийслэлийн Засаг дарга; -Санхүү, эдийн засгийн дэд сайд; -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд; -Эрүүл мэндийн дэд сайд; -Дэд бүтцийн дэд сайд; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд; -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд; -Үйлдвэр, худалдааны дэд сайд; -Цагдаагийн ерөнхий газрын дарга; -Хилийн цэргийг удирдах газрын дарга; -Зэвсэгт хүчний ерөнхий штабын нэгдүгээр орлогч дарга; -Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга; -Засгийн газрын (ахлах) референт; -“НИК” ХК-ийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор); -Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга (тохиролцсоноор). |
| Нарийн бичгийн дарга | -Улсын иргэний хамгаалалтын газрын дэд дарга. |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
Н.ЭНХБАЯР
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД
Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 23—ны өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Яамдын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

Ерөнхий чиг үүргийн яамд:

а/Гадаад хэргийн яам:

-Хөрш орнуудын газар;

-Ази, Америкийн газар;

-Европ, Араб, Африкийн газар;

-Олон талт хамтын ажиллагааны газар /

Олон талт хамтын ажиллагааны нэгдүгээр хэлтэс, Олон талт хамтын ажиллагааны хоёрдугаар хэлтэстэй/;

-Төрийн захиргааны удирдлагын газар / Хүний нөөцийн хэлтэс, Захиргааны хэлтэс, Харилцаа холбооны хэлтэс, Санхүү, аж ахуйн хэлтэстэй/;

-Эрх зүй, консулын газар /Консулын хэлтэс, Эрх зүйн хэлтэс, Хилийн тасагтай/;

-Бодлого, төлөвлөлт, мэдээлэл, үнэлгээний газар /Хэвлэл мэдээллийн хэлтэс, Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Орчуулгын хэлтэстэй/;

-Еслолын хэлтэс.

б/Санхүү, эдийн засгийн яам:

-Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар;

-Төсвийн бодлого, зохицуулалтын газар;

-Төрийн захиргааны удирдлагын газар;

-Төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газар;

-Эдийн засгийн хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтын газар;

-Салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газар;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Нягтлан бодох бүртгэлийн хэлтэстэй/.

в/Хууль зүй, дотоод хэргийн яам:

-Хууль зүйн бодлогын газар;

-Төрийн захиргааны удирдлагын газар

/Гадаад харилцааны хэлтэстэй/;

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Шалган зааварлах хэлтэстэй/;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

Чиглэлийн яамд:

г/Байгаль орчны яам:

-Стратегийн төлөвлөлт, удирдлагын газар;

-Төрийн захиргааны удирдлага, мэдээллийн газар /Санхүү, аж ахуйн хэлтэстэй/;

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын хэлтэстэй/;

-Байгаль орчны улсын хяналт, үнэлгээний газар;

-Хамтын ажиллагааны хэлтэс /Олон улсын төслийн албатай/.

д/Батлан хамгаалах яам:

-Стратегийн төлөвлөлт, удирдлагын газар /Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Улсын дайчилгааны хэлтэс, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй/;

-Төрийн захиргааны удирдлагын газар / Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хүний нөөцийн удирдлагын хэлтэс, Хэвлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй/;

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Зохицуулалтын хэлтэс, Санхүүгийн хэлтэстэй/;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Мэдээллийн сангийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй/.

е/Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам:

-Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар;

-Бага, дунд боловсролын бодлого, зохицуулалтын газар;

-Соёл, урлагийн бодлого, зохицуулалтын газар;

-Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар;

-Эдийн засаг, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

ж/Дэд бүтцийн яам:

-Түлш, эрчим хүчний бодлого, зохицуулалтын газар;

-Зам, тээвэр, мэдээлэл, холбоо, аялал, жуулчлалын бодлого, зохицуулалтын газар;

-Барилга, хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар;

-Төрийн захиргааны удирдлагын газар / Хамтын ажиллагааны хэлтэстэй/

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

з/Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам:

-Стратегийн төлөвлөлтийн газар;

-Төрийн захиргааны удирдлагын газар;

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар;

-Гадаад харилцааны хэлтэс.

и/Үйлдвэр, худалдааны яам:

-Геологи, эрдэс баялгийн бодлого,

зохицуулалтын газар;

-Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газар / Жижиг, дунд үйлдвэрийн хэлтэстэй/;

-Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газар;

-Төрийн захиргааны удирдлагын газар;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

к/Хүн, хөдөө аж ахуйн яам:

-Стратегийн төлөвлөлт, бодлогын газар / Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй/;

-Төрийн захиргааны удирдлагын газар / Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн хэлтэстэй/;

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Мал аж ахуй, усжуулалтын хэлтэс, Газар тариалан, техник технологийн хэлтэс, Хүнсний хэлтэс, Хөдөө аж ахуйн сангийн хэлтэстэй/;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

л/Эрүүл мэндийн яам:

-Стратегийн төлөвлөлтийн газар /Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Хамтын ажиллагааны хэлтэс, Хүний нөөцийн хэлтэстэй/;

-Төрийн захиргааны удирдлагын газар / Тамгын хэлтэс, Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс, Хэвлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй/;

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс, Эмнэлгийн тусламжийн хэлтэс, Техник, технологийн хэлтэстэй/;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

2.Яамдын орон тоо, цалингийн санг энэ оны 9 дүгээр сарын эхний хагаст багтаан Засгийн газарт оруулж батлуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч боловсруулан Засгийн газарт оруулж, энэ талаар Улсын Их Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж эхэлсний дараа "Яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг шинээр буюу шинэчлэн боловсруулж, Засгийн газарт оруулан батлуулахыг Сайд нарт даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан дор дурдсан тогтоолуудын зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

а/"Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг

зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 140 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл;

б/"Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл;

в/"Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 175 дугаар тогтоолын 2, 3 дугаар зүйл;

г/"Гэгээрлийн яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 178 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл;

д/"Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 28 дугаар тогтоолын 2 дугаар зүйл;

е/"Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 171 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл;

ж/"Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 131 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл;

з/"Хууль зүйн яамны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл;

и/"Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 174 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД**

Н.ЭНХБАЯР

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА**

Ө.ЭНХТҮВШИН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гарган,
Хянг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487